



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2025 оны 02 сарын 27 өдөр

Дугаар 57

Улаанбаатар хот

Сонгон шалгаруулалт зохион байгуулах тухай

Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5^{1.1.2}, 5^{1.1.11} дэх заалт, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2020 оны А/45 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Монгол Улсад Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системийг нэвтрүүлэхэд баримтлах бодлогын чиглэл”, Цахим хөгжил харилцаа холбооны сайдын 2023 оны А/42 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт”, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны 106 тоот тогтоолын хавсралтаар баталсан “Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Радио давтамжийн 3300-3400 МГц, 3500-4000 МГц-ийн зурвасыг Дараа үеийн хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн системд ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт”-ыг 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс зарлаж, сонгон шалгаруулалтын баримт бичгийг энэхүү тогтоолын хавсралт ёсоор баталсугай.
2. Сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, үнэлгээний ажлын хэсэг байгуулж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-т үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ЧИНЗОРИГ

ГИШИЙД

Б.АНХБААТАР

Б.БАТЗОРИГ

Ч.ЗОЛБАЯР

А.ЛУВСАН-ОЧИР

Н.МАНДАХБААТАР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР